



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/30

Баян-Өндөр сум

Элэгний В, Д вирус тоолох оношилгоонд шаардлагатай
хөрөнгө гаргах, хуваарилах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, ЭМС-ын 2023 оны А/363 тоот тушаал "Гепатитын В, Д вирусын халдвартай иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээний тухай" 1.3 дах заалт, ЭМС-ын 2024 оны А/18 тоот тушаал "Журам, заавар батлах тухай" 3.4.2 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Элэгний В, Д вирусыг тоолох лабораторийн үйл ажиллагаанд шаардлагатай урвалж, нэмэлт хэрэгслийг худалдан авах жагсаалтыг нэгдүгээр, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үйл оношийн тасагт олгох хуваарийг хоёрдугаар, зарцуулалтын тайлангийн маягтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Филтертэй хошуу, вирусын нуклейн хүчил ялгах цомогийн чанар, хадгалалт, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Эмийн бодлогын хэрэгжилт, чанар, аюулгүй байдал зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн (О.Анхбаяр)-т, хавсралтын дагуу хүлээн авах акт үйлдэх, анхан шатны бүртгэлийг бүртгэлжүүлэх, хуваарийн дагуу олгож ажиллахыг Эрүүл мэндийн газрын нярав (Б.Алтанзагас) -т тус тус үүрэг болгосугай.

3. Хуваарийн дагуу олгосон лабораторийн урвалж, нэмэлт хэрэгслийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавихыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал (Ц.Наран-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

4. Шаардлагатай 959,000 (есөн зуун тавин есөн мянган) төгрөгийг төсөл хөтөлбөрийн бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг Салбарын санхүү бүртгэл, мэдээлэл, нягтлан бодохын ажилтан (Н.Чулуун-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.


5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн ахлах мэргэжилтэн (А.Ганчимэг)-т даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ


Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны
04-р сарын 18-ны 1/30 өдрийн
тушаалын нэгдүгээр хавсралт



**ЭЛЭГНИЙ В, Д ВИРУС ТООЛОХ ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ШААРДЛАГАТАЙ УРВАЛЖ, НЭМЭЛТ ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАН АВАХ ЖАГСААЛТ**

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт үнэ /төг/
1	Филтертэй хошуу 2-200мкм №96	Хайрцаг	3	24,000	72,000
2	Филтертэй хошуу 20мкм №96	Хайрцаг	1	23,000	23,000
2	Вирусын нуклейн хүчил ялгах цомог№48	Хайрцаг	3	288,000	864,000
Нийт					959,000

Боловсруулсан:  О.Анхбаяр /ЭБХЧАБЗХХМэргэжилтэн/

Хянасан:  Н.Чулуун-Эрдэнэ /ССБМНБАжилтан/

Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны
04-р сарын 18-ны 1/30 өдрийн .
тушаалын хоёрдугаар хавсралт



**ФИЛТЕРТЭЙ ХОШУУ, ВИРУСЫН НУКЛЕЙН ХҮЧИЛ ЯЛГАХ ЦОМОГ
ХУВААРИЛАХ ТУХАЙ**

№	Урвалж, нэмэлт хэрэгсэл	БОЭТ-ийн үйл оношийн тасаг			
		Тоо ширхэг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт үнэ /төг/
1	Филтертэй хошуу 2-200мкм №96	3	Хайрцаг	24,000	72,000
2	Филтертэй хошуу 20мкм №96	1	Хайрцаг	23,000	23,000
3	Вирусын нуклейн хүчил ялгах цомог №48	3	Хайрцаг	288,000	864,000
4	Нийт				959,000

Боловсруулсан:  О.Анхбаяр /ЭБХЧАБЗХХМэргэжилтэн/

Хянасан:  Н.Чулуун-Эрдэнэ /ССБМНБАжилтан/



Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны 04-р сарын 18-ны өдрийн 4/30 тушаалын гуравдугаар хавсралт

ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАНГИЙН МАЯГТ

БАЙГУУЛЛАГЫН НЭР:

№	нэр	Хэмжих нэгж	Хүлээн авсан тоо ширхэг	Зарцуулсан тоо ширхэг	Үлдэгдэл тоо ширхэг	Хүлээн авсан хүний гарын үсэг	Зарцуулсан хүний гарын үсэг
	Филтэртэй хошуу						
	Вирусын нуклейн хүчил ялгах цомог						

Хөтөлсөн:

Хянасан: